


# УХАТ-ын ТЗЭ байгууллагуудын үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулах, тарифт тусгасан элэгдлийн зардлыг хянах тухай




ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

*Тэгш,  
Чанартай,  
Найдвартай,  
Хүртээмжтэй үйлчилгээг бүгдэд*




# Агуулга

- ❖ Усны салбарын хөрөнгийн удирдлага
- ❖ Гадаад орнуудын туршлага
- ❖ Салбарт тулгарч буй асуудлууд
- ❖ Бусад салбарын туршлага
- ❖ Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэлийн хэмжээ танилцуулга
- ❖ Тарифт тусгасан элэгдлийн зардлыг хянах тухай




# Усны салбарын хөрөнгийн удирдлага




Хөрөнгийн менежмент гэдэг нь ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд хангагч байгууллагуудын их, урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэх төлөвлөгөө, эд хөрөнгө техник, тоног төхөөрөмж (насос, мотор, хоолой гэх мэт)-ийг цаг хугацаанд нь засаж, сольж эсвэл шинэчлэх боломжтой байлгах, энэ ажилд зарцуулагдах мөнгөн хөрөнгийг бэлэн байлгах асуудлыг зохицуулах тасралтгүй үйл явц гэж тодорхойлж болно.



# Усны салбарын хөрөнгийн удирдлага



## Хөрөнгийн эрчимжилт



# Усны салбарын хөрөнгийн удирдлага



*Хөрөнгийг удирдсанаас хүлээх үр ашиг нь дараах зүйлс байж болно. Үүнд:*

- Дэд бүтэц, хөрөнгийг нөхөн сэргээх, засварлах, солих талаарх шийдвэрийг сайжруулж оновчтой болгох,
- Системийн тогтвортой байдлыг онцгой анхаарснаар хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах,
- Үйл ажиллагааны болон санхүүгийн ухаалаг, зөв төлөвлөлтөд суурилсан үнийг тогтоох,
- Үйл ажиллагаа тогтвортой явуулахад шаардагдах арга хэмжээнүүдийг оновчтой төлөвлөж, төсөвт тусгах,
- Үйлчилгээний хүлээлт ба зохицуулалтын шаардлагуудыг хангах,
- Давагдашгүй хүчин зүйл тохиолдох, гэнэтийн осол аваарын үед авах арга хэмжээг илүү шуурхай болгох нөхцөлийг хангах,
- Аюулгүй ажиллагаа, хөрөнгийн аюулгүй байдлыг сайжруулах,
- Үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг нийтэд нь бууруулах явдал юм.

# Гадаад орнуудын туршлага



Их британи. 1989 онд Англи болон Уэльсэд усны салбар хувьчлагдсан. Одоо бүсийн хэмжээнд бие даан үйл ажиллагаа явуулдаг 18 томоохон хувийн компани болж задарсан байна. Эдгээр компаниуд хувийн хөрөнгө оруулалтаар ажиллаж, хэрэглэгчдээс хураасан орлогоороо үйл ажиллагаагаа бүрэн бие даан явуулах түвшинд хүрсэн ажээ. Ус хангамжийн компаниуд 22 сая орчим айл өрх, 2 сая гаруй ҮААНБ-д үйлчилгээ үзүүлдэг. Салбарын хөрөнгө 64.7 тэрбум фунтээр үнэлэгдэж, жилд дунджаар 12 тэрбум шахам фунтын орлоготой ажилладаг.



# Гадаад орнуудын туршлага



- Ofwat усны компаниудын үнийг хянах явцдаа хөрөнгө зардлыг хөрөнгө оруулагчдын санхүүжүүлэлт болон түүхэн зардлын өгөөж дээр тулгуурлан зах зээлийн үнээр капиталын өртгийг тооцоолох замаар тодорхойлно. Бусад эдийн засгийн зохицуулагчидтай адилаар Ofwat нь өмчийн өртөг, өр төлбөрийн өртгийг ашиглан тооцоолсон капиталын жигнэсэн дундаж өртгийг тогтоодог байна.
- Ofwat усны компаниудын элэгдлийг хуримтлалын тусгай дансанд хадгалан, зарцуулалтад хяналт тавьж, зөвлөмж өгдөг байна.


# Гадаад орнуудын туршлага



АНУ: Тарифт тооцох өгөөжийн зөвшөөрөгдсөн хувь хэмжээ нь тухайн ашиглалтын компанийн үнэ тарифт суулгасан хувийн жингээр илэрхийлэгдэх өгөөж юм. Энэ нь уг ашиглалтын компанийн капиталын өртөгт үндэслэдэг. Ашиглалтын компанийн капиталын бүтцийн янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүд, өөрөөр хэлбэл түүний өр, давуу эрхтэй хувьцаа, энгийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн жинэлсэн дундаж зардалаар капиталын өртгийг тооцоолдог. Корпорацийн санхүү ба санхүүгийн удирдлагын олон сурах бичигт капиталын өртгийн талаархи ойлголт, түүнийг хэрхэн тооцоолох, түүнд нөлөөлөх хүчин зүйлс зэргийн талаар хангалттай дэлгэрэнгүй авч үзсэн байдаг.




# Салбарт тулгарч буй асуудлууд




1. Хүний үндсэн эрхийг хамгаалах, хүн амын ус хангамжийн тэгш бус байдал → Хүн амын ус хэрэглээний түвшин харилцан адилгүй байна.
2. Баталгаатай, хүлээн зөвшөөрөгдсөн байх нөхцөл зөрчигдөх → Дэд бүтэц хуучирсан, насжилт өндөрсөн
3. Байгаль орчны доройтол, усны болон орчны бохирдол → Хөрс, усны бохирдол нэмэгдэж байна
4. Удирдлага, бүтэц зохион байгуулалт, хууль эрхзүйн орчинд бодлого алдагдаж, давхцал, хийдэл үүссэн → Бодлогын түвшинд уялдаа холбоог сайжруулах
5. Хүний нөөцийн асуудал → Боловсон хүчний чадварыг дээшлүүлэх мэдлэг,



# Салбарт тулгарч буй асуудлууд




1. Шугам хоолойн элэгдэл




Хөдөө орон нутгийн цэвэр  
усны шугам - 91.1%  
Бохир усны шугам – 88.4%


2. Усны эх үүсвэрийн барилга  
байгууламж хуучирсан




9 аймгийн эх үүсвэрийн  
барилга, Дархан, Эрдэнэт,  
Төв, Ховд аймгаас бусад  
аймгийн цэвэрлэх  
байгууламж




# Салбарт тулгарч буй асуудлууд



## Цэвэр усны шугам хоолойн насжилт



# Бусад салбарын туршлага



- Эрчим хүчний зохицуулах хороо
  - 2015 оны 3-р сарын 26 ны 86-р тогтоол Эрчим хүчний ТЗЭ хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох журам
- Бусад байгууллагууд
  - Байгууллагын НББ-ийн бодлогын баримт бичиг /НББОУС 16/




# Элэгдлийн зардал



УХАТ-ын салбар нь урт хугацаанд ашиглах өндөр өртөг бүхий дэд бүтэцтэй байдгийн дээр хэрэглэгчдэд тасралтгүй найдвартай үйлчилгээ үзүүлэх үндсэн зорилгоо биелүүлэхэд засвар үйлчилгээ хийх, шинэчлэх нөөц хөрөнгөтэй байх зайлшгүй шаардлага тулгардаг. Үүнээс шалтгаалан бэлэн бусаар бүртгэлд тусгадаг элэгдлийн зардлыг бүхлээр нь буюу хэсэгчлэн тарифт тусгаж, бодитойгоор хуримтлал үүсгэх асуудал чухлаар тавигддаг. Үндсэн хөрөнгийг ашиглах явцад түүний эд ангиуд хуучирч муудаж элэгдэж байдаг тул уг элэгдлийн зардлыг бүтээгдэхүүний өртөгт шингээх болон зардалд тооцохыг элэгдлийн зардал буюу элэгдүүлэх гэнэ.

Монгол улсад 2012 он хүртэл Сангийн яамнаас гаргасан журмын дагуу элэгдэл байгуулж байсан бөгөөд харин үүнээс хойш аж ахуйн нэгж бүр олон улсын стандарт болон санхүүгийн бодлогодоо тулгуурлан элэгдэл байгуулж байна. Ус хангамжийн салбарын байгууллагууд өмнө хэрэглэж байсан журмаар тогтоосон хувь хэмжээг мөрдөн ажиллаж байсан.

# Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох аргууд



Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох дараах аргууд байдаг. Үүнд:

- Шулуун шугамын арга
- Бүтээгдэхүүний нэгжид ногдуулах арга
- Үлдэгдлийг давхар бууруулах арга
- Жилүүдийн нийлбэрийн арга
- Дахин үнэлэх арга

УХАТ-ын салбарт ихэвчлэн шулуун шугамын аргаар элэгдэл тооцож байна. Энэ нь ашиглах хугацааны дотор үндсэн хөрөнгийн өртгийг адил тэнцүү хэмжээгээр өртөгт хуваарилах арга бөгөөд **Анхны өртөг - Үлдэх өртөг / Ашиглах хугацаа (жилээр) = Үндсэн хөрөнгийн жилийн элэгдэл** гэсэн томъёоллтой байна.

# Элэгдэл байгуулсан байдал




2016 оны тайлангаас

ТЗЭ	Үндсэн хөрөнгө	Байгуулсан элэгдэл	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл	Авлага
Аймаг орон нутгийн НАА-н байгууллагууд	246,229,586.2	11,283,903.3	9,406,234.9	12,854,243.2
УБ хотын ОНӨААТҮГ	243,213,854.5	14,855,947.3	20,350,330.3	8,852,095.7
Хувийн компаниуд	46,764,597.5	671,761.5	3,852,854.3	6,868,931.6
Нийт дүн	536,208,038.2	26,811,612.1	33,609,419.5	28,575,270.6

Хувийн 70 компаниас:	Элэгдэл бүрэн байгуулсан	26	Элэгдэл байгуулсан хувь
	Дутуу байгуулсан	17	О/н 5
	Огт байгуулаагүй	22	Х/х 1.5
	Хэт их хэмжээтэй	5	Н/Ө 6.1
			Улс дунд 4.8



# Элэгдэл байгуулсан байдал



- 73 ТЗЭ-ээс –дундаж 9.4 %
  - Элэгдэл байгуулаагүй 16
    - "Хайспийд" ХХК, "Хүннү хотхон" ХХК, "Тунгалаг буянт дуут" ХХК, "Монхауз сервис" ХХК г.м
  - Хэвийн түвшинд байгуулсан 46
  - Зохих түвшингээс өндөр 11
    - "Эрин барилга" ХХК, "Хаусинг холд" ХХК, "Таункомфорт" ХХК, "Цонхлон үйлс" ХХК, "Дай цэцэн" ХХК,



# ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ ТОГТООСОН ТУХАЙ



## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ хууль

10.1.2.энэ хуулийн 15.1.11-д заасан үндсэн хөрөнгийн элэгдэл,  
хорогдлын шимтгэлийн хэмжээг тогтоох;

ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 27-НЫ  
ӨДРИЙН 40 ДҮГЭЭР ТОГТООЛ

2018 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллана.

<http://www.legalinfo.mn/annex/?lawid=13345>

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Хууль эрх зүйн үндэслэл

## ► НББ-ийн тухай хууль

- 4.1.Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө:
  - 4.1.1.Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт;
- 4.2.Энэ хуулийн 4.1.1-д заасан стандартыг мөрдөх аж ахуйн нэгж, байгууллагын ангилал, шалгуур үзүүлэлтийг хуульд нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоож, нийтэд мэдээлнэ. Энэ ангилалд доор дурдсан аж ахуйн нэгж, байгууллагыг заавал хамруулна:
  - 4.2.4.төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж;
  - 4.2.5.эрчим хүч, дулаан, уур усаар хангах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг нийтийн үйлчилгээний байгууллага;

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### ► 17 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэлийн удирдлагын тогтолцоо

- 17.1.4.эдийн засгийн салбарын хэмжээнд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, заавар, аргачлал, маягтыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, мөрдүүлэх;



# УХАТ-ЫН ТЭЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



- Стандартыг анх 1982 оны 3 дугаар сард НББОУС 16 Үндсэн Хөрөнгийн Бүртгэл нэрээр хэвлэн нийтэлсэн бөгөөд 1993 онд **НББОУС 16 Үндсэн хөрөнгө** болгон өөрчилсөн
- Стандартын зорилго нь
  - үндсэн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийн хандлагыг тодорхойлох
  - санхүүгийн тайлан хэрэглэгчдэд аж ахуйн нэгжүүдийн үндсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгө оруулалт, түүний өөрчлөлтийн талаар мэдээлэл өгөх
  - Үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн бүртгэл, хүлээн зөвшөөрөлт,
  - Тэдгээрийн дансны үнийн тодорхойлолт,
  - Элэгдлийн өөрчлөлт, үнэ цэнийн бууралтын гарз зэрэгтэй холбоотой бүртгэлийн асуудлыг авч үзнэ.



# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



- НББОУС 16 Үндсэн хөрөнгө
  - Дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед хөрөнгийн өртгийг хүлээг зөвшөөрч бүртгэнэ.
    - ААН-д ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авч ирэх боломжтой байх,
    - Хөрөнгийн өртгийг үнэн зөв бүртгэх боломжтой байх /16.7/

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
<b>Нэг. Барилга, байгууламж</b>			
1.1	Төмөр бетон, угсармал байшин, төмөр сараалжтай ердийн, тоосгон болон блокон барилга	60	1.7
1.2	Холимог бүтэцтэй болон дүнзэн байшин	25	4.0
1.3	Карказгүй төмөр бетон, тоосгон болон блокон барилга	20-40	5-2.5
1.4	Зуслангийн модон байшин, угсармал болон бусад хөнгөвчилсөн хийцийн модон, сэндвичэн барилга	15-20	6.7-5
1.5	Зоорь, хүлэмж, малын хашаа	15	6.7
1.6	Услалтын систем, хөргөх цамхаг	25	4
1.7	Төмөр чингэлэг	60	1.7
1.8	Угсармал төмөр бетон далан	30	3.3
1.9	Цутгамал бетон далан	15	6.7
1.10	Асфальт бетон хучилттай зам, талбай	25	4
1.11	Цемент бетон хучилттай зам, талбай	15	6.7
1.12	Гэр	5-15	20-6.7

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
<b>Нэг. Барилга, байгууламж</b>			
1.14	Усан сан		
1.14.1	Төмөр бетон	70	1.4
1.14.2	Ган	15-20	6.7-5
1.14.3	Хуванцар	8-10.	12.5-10
1.15	Ус дамжуулах, түгээх шугам хоолой		
1.15.1	Ган	15-20	6.7-5
1.15.2	Ширэм	40	2.5
1.15.3	Хуванцар	50-60	2-1.7
1.16	Бохир усны гаргалгаа, цуглуулах, татан зайлуулах шугам хоолой		
1.16.1	Ширэм	40	2.5
1.16.2	Хуванцар	25-50	4-2.
1.16.3	Вааран	20-30	5-3.3
1.16.3	Асбесто цементэн	25-35	1-2.8
1.17	Ус хангамжийн хяналтын худаг, бохир усны үзлэгийн худаг	30	3.3

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
<b>Нэг. Барилга, байгууламж</b>			
1.18	Хлорын шугам	10	10
1.19	Дулааны шугам (ган)	20	5
1.20	Барилгын суурийг уснаас хамгаалах далд шугам	30	3.33
1.21	Ус цэвэршүүлэх байгууламж	25-30	4-3.3
1.22	Бохир ус цэвэрлэх байгууламж, тунгаагуур, лагийн талбай, элсний талбай	15-30	6.7-3.3
1.23	Бохир ус цэвэрлэх байгууламжийн эзэлхүүний байгууламжууд	10-30	10-3.3
1.24	Лаг боловсруулах байгууламж	10-20	10-5
1.25	Төмөр торон хашаа	10	10
1.26	Бетонон хашаа	20	5
1.27	Асфальт бетон хучилттай зам	15	6.7
1.28	Цемент бетон хучилттай зам	25	4
1.29	Гадна реклам чимэглэл, тэмдэг	5	20
1.30	Гадна гэрэлтүүлгийг төхөөрөмж, сандал сүүдрэвч хогийн сав	10	10

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
<b>Хоёр. Ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмж</b>			
2.1	Цэвэр усны насос	6-15	16.7-10
2.2	Бохир усны насос	3-6	33.3-16.7
2.3	Лагийн насос	4	25
2.4	Цахилгаан тоног төхөөрөмж, хэрэгслүүд	6-15	16.7-6.7
2.5	Тоолуур, хэмжих хэрэгсэл	3-8	33.3-12.5
2.5	Хаалтууд	4-10	20-10
2.6	Теле механикийн тоног төхөөрөмж	4	25.00
2.7	Удирдлагын щит, самбар, автомат	8-15	12.5-6.7
2.8	Ариутгал, халдваргүйжүүлэлтийн тоног төхөөрөмж	6	16.7
2.9	Лабораторийн тоног төхөөрөмжүүд	3.-10	33.3-10
2.10	Кабель	3-6	33.3-16.7
2.11	Агаарын хаалт	25	4
2.12	Вакуум таслуур	15	6.70
2.13	Ус хангамж, ариутгах татуургын бусад тоног төхөөрөмжүүд	4-10	25-10



# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
2.14	Сантехникийн болон бусад багаж хэрэгсэл, гагнуурын аппарат	3-6	33.3-16.7
2.15	Ялтсан бойлер, дулааны узель	15	6.6
2.16	Дизель генератор, трансформатор	15-20	6.7-5
2.17	Халаалтын тогоо	10	10
2.18	Засварын багаж, тоног төхөөрөмж /холбоо, сүлжээ, автоматжуулалт болон бусад/	4-6	25-16.7
<b>Гурав. Тээврийн хэрэгсэл</b>			
3.1	Угааж цэвэрлэх, тослох, цэнэглэх, задалж угсрах зэрэг зориулалтын тоног төхөөрөмж	6	17
3.2	Ачааны болон суудлын автомашин, автобус, тусгай зориулалтын машин, механизм, тээврийн хэрэгсэл /экскаватор, кран, өрмийн машин, бульдозер болон бусад/	10	10
3.3	Усны галт тэрэг	25	4

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
2.14	Сантехникийн болон бусад багаж хэрэгсэл, гагнуурын аппарат	3-6	33.3-16.7
2.15	Ялтсан бойлер, дулааны узель	15	6.6
2.16	Дизель генератор, трансформатор	15-20	6.7-5
2.17	Халаалтын тогоо	10	10
2.18	Засварын багаж, тоног төхөөрөмж /холбоо, сүлжээ, автоматжуулалт болон бусад/	4-6	25-16.7
<b>Гурав. Тээврийн хэрэгсэл</b>			
3.1	Угааж цэвэрлэх, тослох, цэнэглэх, задалж угсрах зэрэг зориулалтын тоног төхөөрөмж	6	17
3.2	Ачааны болон суудлын автомашин, автобус, тусгай зориулалтын машин, механизм, тээврийн хэрэгсэл /экскаватор, кран, өрмийн машин, бульдозер болон бусад/	10	10
3.3	Усны галт тэрэг	25	4
<b>Дөрөв. Тавилга, эд хогшил</b>			
4.1	Тавилга, эд хогшил	10	10

# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл, зүйл	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Жилд байгуулах элэгдлийн хэмжээ /хувь/
<b>Дөрөв. Тавилга, эд хогшил</b>			
4.1	Тавилга, эд хогшил	10	10
4.2	Бие бялдаржуулах болон биеийн тамирын техник хэрэгсэл	5	20
<b>Тав. Офисын техник хэрэгсэл</b>			
4.3	Компьютер, техник хэрэгсэл	5-8	20-12.5
4.4	Хөгжмийн хэрэгсэл, дуу авиа, радио, телевиз	5	20
4.5	Мэдээлэл технологийн тоног төхөөрөмж, программ хангамж	3-5	33.3-20
4.6	Дохиолол хамгааллын техник хэрэгсэл	10	10



# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



- Тайлбар: 1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллага, хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа болон элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16 “Үндсэн хөрөнгө”-ийг мөрдөнө.
- 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид өөрсдийн үйл ажиллагаа, онцлогт тохируулан ашиглалтын хугацааг сонгоно.
- 3. Үндсэн хөрөнгийг ашиглаж эхлэх үеээс эхлэн элэгдэл тооцно. Үндсэн хөрөнгийг ашиглаж эхлээгүй, үйлдвэрлэл явуулаагүй үед элэгдлийн зардал тэг байж болно.
- 4. Гадаад, дотоодын байгууллагуудын буцалтгүй тусламжаар, бусдаас үнэ төлбөргүйгээр болон балансаас балансад шилжүүлэн авсан, шүүхийн шийдвэр, өр барагдуулалтаар хүлээн авсан зэрэг нөхцөлүүдээр шилжин ирсэн үндсэн хөрөнгийн элэгдлийг Хот, суурины ус ханамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл (цаашид Зохицуулах зөвлөл гэх)-өөс зөвшөөрөл авсны дараа байгуулж эхэлнэ.



# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



- 5. Үндсэн хөрөнгийн ашиглахад хугацааг хавсралтад заасныг жишиг болгон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгана.
- 6. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг дараах нөхцөлд эрх бүхий байгууллагаар хийлгэнэ.
  - - Ашиглалтын хугацаа нь дуусч, элэгдлийн зардлаараа анхны өртгөөр бүрэн нөхсөн боловч техникийн комиссын шийдвэрээр цаашид ашиглах боломжтой гэсэн дүгнэлт гарсан;
  - -Гадаад, дотоодын байгууллагуудын буцалтгүй тусламжаар, бусдаас үнэ төлбөргүйгээр болон балансаас балансад шилжүүлэн авсан, шүүхийн шийдвэр, өр барагдуулалтаар хүлээн авсан зэрэг нөхцөлүүдээр шилжин ирсэн үндсэн хөрөнгийн үнэ нь зах зээлийн үнээс хэт өндөр эсвэл хэт доогуур байх;
  - -Хөрөнгийн дансны үнэ нь зах зээлийн үнээс хэт доогуур болон дээгүүр бол;



# УХАТ-ЫН ТЗЭ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БАЙГУУЛАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЛЭГДЭЛ, ХОРОГДЛЫН ШИМТГЭЛИЙН ХЭМЖЭЭ



- 7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь Үндсэн хөрөнгөндөө дахин үнэлгээ хийлгэх тохиолдолд дахин үнэлгээ хийх болсон үндэслэл, холбогдох мэдээллийг хангалттай баримтаар баталгаажуулан Зохицуулах зөвлөлд ирүүлж зөвшөөрөл авна.
- 8. Зохицуулах зөвлөлөөс элэгдлийн зардлын хуримтлал болон зарцуулалтад хяналт тавьж ажиллана.
- 9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд нь үйлчилгээний тарифт тусгагдсан элэгдлийн зардлыг хуримтлал байдлаар төвлөрүүлнэ.
- 10. Санхүүгийн тайланд тусгагдсан элэгдлийн зардал, хуримтлагдсан дүн, өөрчлөлт, үйлчилгээний тарифт тусгагдсан элэгдлийн хуримтлалыг Тусгай зөвшөөрлийн хүрээнд үндсэн хөрөнгийн ангилал тус бүрээр хавсралт-д заасны дагуу гаргаж санхүүгийн жилийн эцсээр Зохицуулах зөвлөлд тайлагнана.
- 11. Хуримтлагдсан элэгдлийн зардлаас зарцуулалт хийхдээ Зохицуулах зөвлөлтэй зөвшилцсөн батлагдсан төлөвлөгөөг баримтална.



# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭЛЭГДЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл зүйл	Хөрөнгийн үнэлгээ /мян.төг/	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Тухайн жилд байгуулсан элэгдлийн хэмжээ /мян.төг/	Хуримтлагдсан элэгдлийн хэмжээ /мян.төг/	Тайлбар
1	Нэг. Барилга байгууламж					
1.1						
1.2						
	Дүн					
2	Хоёр. Тоног төхөөрөмж					
2.1						
	Дүн					
3	Гурав. Тээврийн хэрэгсэл					
3.1						
3.2						
	Дүн					

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭЛЭГДЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН



Д/д	Үндсэн хөрөнгийн төрөл зүйл	Хөрөнгийн үнэлгээ /мян.төг/	Элэгдэл тооцоход баримтлах хугацаа /жил/	Тухайн жилд байгуулсан элэгдлийн хэмжээ /мян.төг/	Хуримтлагдсан элэгдлийн хэмжээ /мян.төг/	Тайлбар
4	Дөрөв. Тавилга, эд хогшил					
4.1						
	Дүн					
5	Тав. Бусад					
5.1						
	Дүн					
6	НИЙТ ДҮН					
7	Үүнээс тухайн жилд тарифт тусгасан					





# Тарифт тусгасан элэгдлийн зардлыг хянах



- Элэгдэл, хөрөнгө оруулалт, их засварын сан, эрсдэлийн сангуудын эх үүсвэр нь тухайн жил батлагдсан бизнес төлөвлөгөөнд үндэслэн баталсан тарифт шингээсэн хувь хэмжээний дагуу ус хангам, ариутгах татуургын үйлчилгээний төлбөрийн орлогоос хуримтлуулах мөнгөн хөрөнгө юм.
- Элэгдэл, хөрөнгө оруулалт, их засварын сангаас зарцуулалт хийхдээ Зохицуулах зөвлөлтэй зөвшилцсөн батлагдсан төлөвлөөг баримтална.
- Элэгдэл, хөрөнгө оруулалт, их засварын санг хэд хэдэн компани хамтран байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд дүрэм, гэрээгээ Монгол улсын хууль тогтоомжийн дагуу байгуулан, Зохицуулах зөвлөлөөс хөндлөнгийн хяналт тавих боломжийг бүрдүүлсэн байна. Гэрээнд оролцогчдын эрх үүрэг, хөрөнгийн хэмжээ, зарцуулалтыг нарийвчлан тусгана.



# Тарифт тусгасан элэгдлийн зардлыг хянах



- Эрсдэлийн санд хуримтлагдсан хөрөнгөөс зарцуулалт хийхдээ тухайн ТЗЭ байгууллагын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэнэ. Хамтын сантай тохиолдолд оролцогч байгууллагын захирлууд хамтын хурлаар шийдвэрлэнэ.
- ТЗЭ нь жил бүр Зохицуулах зөвлөлд хүргүүлэх санхүүгийн тайланд Элэгдэл, хөрөнгө оруулалт, их засварын сан, эрсдэлийн сангуудын тухайн жилийн зарцуулалтын тайланг хавсарган ирүүлнэ.
- Зохицуулах зөвлөлөөс тус сангийн бүрдэлт болон зарцуулалтад хяналт тавьж ажиллана.



**АНХААРАЛ ТАВЬСАН ТА  
БҮХЭНД БАЯРЛАЛАА**

